

Улс хоорондын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн  
үйл ажиллагаанд шалгалт хийсэн тухай

Зам, тээврийн яамны 2016 оны хяналт шалгалтын төлөвлөгөө болон тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан 11 дугаартай удирдамжийн дагуу Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтэстэй хамтран “Атибус” ХХК болон “Тэнүүн огоо” ХХК-иудын үйл ажиллагааг 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн ажлын 10 хоногт хяналт шалгалт хийсэн.

Шалгалтын явцад дээрх аж ахуйн нэгж байгууллагууд нь Автотээврийн хяналтын чиглэлээр 15, Хөдөлмөр хамгааллын чиглэлээр 3 зөрчил илэрсэн ба зөрчил дутагдлыг арилгуулахаар “Атибус” ХХК-д 12 заалттай 38/07/077/15, “Тэнүүн огоо” ХХК-д 6 заалттай 38/07/077/16 тоот улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг тус тус хүргүүлэв.

Мөн зөрчил гаргасан 2 албан тушаалтанд 60000 төгрөгийн нийт 120000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, барагдуулав.